

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Хүрэлбаатар	Дугаар	L155
Оршин суугаа аймаг	Баянхонгор	Оршин суугаа сум	Баянбулаг
Төрсөн газар		Төрсөн он	
Ажил мэргэжил	Гандандашилиин хийдийн ловон лам		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Гандандашилиин хийд, Дэлэвэлбээлэн хийд, Барууны хийд, Сангийн далайн хийд, Билүүтийн хийд, Бугатын хийд, Хадатын хийд	Сүм хийдийн дугаар	БХГБ 085, БХББ 079
Одоогийн сүм хийд	Гандандашилиин	Сүм хийдийн дугаар	БХББ 021
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 9-р сарын 4	Ярилцлага авсан хүн	Мөнхнасан



Баянхонгор аймгийн Баянбулаг сумын

Гандандашилиин хийд, Дэлэвэлбээлэн хийд

Асуулт:-Та хийдийн тухай ярьж өгнө үү, хэдэн онд байгуулагдсан бэ?

Хариулт:-Манай хийд анх эхэлж 1989 оны 4 сард шавыг нь тавиад тэгээд гэрт хурал хүрж байсан. 1990 оны 10 сарын 24-нд анх эхэлж хийдээ барьж хийддээ орсон. Манай сумын нутаг дэвсгэрт дээр үед Пүрэв гүний хошуу гэж байгуулагдаж байсан. Тэр үеийн нутаг дэвсгэрийн харьяагаар бол 5 хийд харьяалагдаж байсан юм байна лээ. Баруун хүрээ хийд Барууны хийд гэж, Сангийн далай хүрээ хийд, Бугатын хүрээ, **Хадатын** хүрээ, одоогоор бол Гурванбулагийн нутгийн харьяа, Билүүтийн хүрээ гээд энэ 5 хүрээ яг манай сумын нутаг дэвсгэрт холбогдож байсан түүхтэй юм билээ. Энэ хүрээнүүдэд сууж байсан 5 хүрээнд шавилан сууж байсан тэр хөгшчүүл бүгдээрээ хамтарч анх эхэлж байгуулагдахдаа бол 30 гаруй хөгшин лам нартай, 4 ажилчинтай, анх эхэлж ингэж

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

байгуулагдаад, тэгээд энэ хийдийг барьсан. Одоо бол өвөл, зуны хоёр дугантай. 90 оны морь жил анхных нь дуган баригдсан. 2003 оны морь жил дараагийнх нь өвлийн дуган барьсан.

Асуулт:-Шашны дээд сургууль, Энэтхэгийн Гомон **дацангуудад** лам нар сурч байна уу?

Хариулт:-Шашны дээд сургуульд 4 оюутан сурч байгаа, урлахуй ухааны дээд сургуульд 4 оюутан, Энэтхэг улсад 1 оюутан сурч байгаа.

Асуулт:-Энэ хийдийг анхалж байгуулсан үүсгэсэн тэр үеийн засаг захиргааны хүмүүс, лам хуврагуудаас та ярихгүй юу?

Хариулт:-Тэр үед сум, нэгдэл гэж байсан. Тухайн үеийн хөгшчүүл, лам Чойсүрэн, Гомбо, Магван, Равдан гэх мэтчилэнгийн ийм хөгшчүүл санаачлаад, тэрнийг тухайн үеийн сум, нэгдлийн дарга **Г.Баянбуу** гэдэг хүн дэмжиж, ингээд ард түмний хандив, дээрээс нь бас сум орон нутгаас хөрөнгө гаргаж, энэ хийдийг анх эхэлж байгуулж байсан юм билээ.

Асуулт:-Энэ хийдийн зүгээс нутаг усны уул овоог яаж тахиж **байна?** дээр үеийн уламжлал нь ямархуу байсан энэ талаар ярьж өгөхгүй юу?

Хариулт:-Манай энд тахилгатай олон уулууд байдаг л даа. Хамгийн гол манай сумын нэрээр нэрлэж байгаа Баянбулаг хайрханаа хамгийн гол уул нь гээд тахидаг. Тэгээд Бугат гэж уул, Баянцагаан уул, Сангийн далай, **Мандал толгой** гээд тахидаг газрууд байгаа. Баянбулагийн овоогоо хамгийн эхэлж тахидаг. Энэ овоог 5 сарын сүүлч 6 сарын эхээр. Тухайн үеийнх нь лусын буулт юмнуудыг харж, өдөр судрыг **нь тохируулж** байгаад тахидаг. Баянбулагийнхаа овоон дээр очиж тахилга ёсоо үйлдээд, тэгээд доор нь Чандмань толгой гэж тал дотор ганц тийм толгой байдаг. Тэр толгой дээр ирж наадам хийж, тэр толгойг тэр чигт нь цагаан идээгээр бүрж ингэж тахидаг. Ийм заншилтай.

Баянцагаан уулыг намар тахидаг. Дээр намрын дунд сарын 17-нд тахидаг байсан юм гэнэ лээ, түүхэндээ бол. Баруун хүрээ, Сангийн далай хүрээний лам нар тахидаг байсан. Тэрнийг болохоор хонины шүүсээр тахидаг. Онцлог нь тэр. Баянбулагийнх нь бол дан цагаан идээгээр тахидаг байсан. Бусад уул нь ерөнхийдөө Баянбулагтай ойролцоо. Манай **Баянбулаг** нэлээн том уул гэж явдаг юм. Баянбулагийг тахиж байгаа өдөр Гурванбулагийн Баянхайрхан болоод өөр газрыг дахиад тахилга авдаггүй гэж. Бас тэр чинь лус **савдагууд** нь цуглардаг юм байна л даа, нэг ёсондоо хамгийн ахмад нь ч юмуу, хамгийн хүндтэй нь ч юмуу тухайн ойр орчиндоо тэр нь Баянбулаг уул юм байгаа юм гэж хөгшчүүл ярьдаг байсан. Давхардуулж тахих юм бол Баянбулаг уулаас бусад нь тахилга авдаггүй гэж. Яагаад гэвэл лус **савдагууд** нь эндээ цугларчихсан байдаг юм гэж ярьдаг байсан.

Асуулт:-Та хийдийнхээ гол гол уншлага, хурал номын тухай ярьж өгөхгүй юу, ямар ямар хурал хурж байна?

Хариулт:-Манай хийд шинийн 8, 15, **Сандуйн** жүд, **Доржзовд**, Цагаан, Ногоон дарь эх, Дарь эхийн мандал **шиваа**, манла, **Дүншигийн чоги**, **дондогжин**, **Логотой гүнрэг** хурдаг, сар бүрийн 29-нд 10 **Хангал**, хурдаг. Ганжуур, **Данжуур** хурна, бусад янз бүрийн юм Цагаан **шүхэртийн дүвжир**, **Чойжилийн дүгжүү**, аврал гүрмийн тийм **номнуудыг**, ер нь нэлээн ном уншдаг даа.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Асуулт:-Зулын 25-наар.

Хариулт:-Зулын 25 намрын адаг сарын 22-ны их дүйцэн мацаг, зуны адаг сарын шинийн 4, зуны эхэн сарын15. Энэ их дөрвөн мацаг. Зулын 25-нд бол зонхов магтаж магтаалаа хураана, орой болохоороо сумаараа нийтээрээ цугларч зул өргөдөг.

Асуулт:-Хийдийнхээ цаашдаа ямархуу ажил хийе, өргөжүүлье гэсэн санаа байна?

Хариулт:-Одоогийн байдлаар шашны дээд сургууль **төгсч** ирсэн хоёр лам байгаа. Одоо энэ сургуулиудад 8,9 хүн сурч байгаа. Энэ хүмүүс төгсөөд ирэхээр ерөнхийдөө боловсон хүчин нэлээн хангалттай болох байх. Тэр үеийнхээ **нөхцөл байдлаас** болж байгаад, ер нь дээрээс ч тиймэрхүү яриа хөөрөө, энэ жил хамба гуай ирээд, ерөнхий баруун бүсийн төв маягийн ч юмуу, шашны нэг бага сургууль маягийн ийм юм болгож өргөжүүлэх магадлал **өндөртэй** газар байна гэж энэ жил явахдаа гэж ярьж байсан л даа.

Асуулт:-Хуучны хүрээ хийдүүдийн тухай ярьж өгөхгүй юу, баруун хүрээний тухай ярих уу?

Хариулт:-Баруун хүрээнд сууж байсан лам нар манай энд байж байсан л даа. Баруун хүрээний ширээний ламтай тийм байсан юм гэнэ лээ, баруун хүрээнд манай баруун талын багийн хүмүүс, Гуулин, Дэлгэрээс, Маралаас ингэж сууж байсан юм билээ. Манай хийд чинь 3 аймгийн 13, 14 сумын сүсэгтэн олонд үйлчилдэг ийм хийд байгаа.

Сангийн далай хүрээ чинь бас наран гэгээний хийд гэж Наран гэгээн гэдэг чинь хоёр удаа төрсөн тийм их түүхтэй хүн байсан юм билээ. Номонд болохоор 40 хотол гэж яадаг юм билээ. Түүхэндээ бол 8 боть сүмбэн зохиосон ийм хүн юм билээ. Наран гэгээний буурал түүх. Тэрнээс одоогийн байдлаар ганцхан боть сүмбэн нь олдоод наадуул нь олдохгүй байгаа. Тийм учраас судлагдаж амжаагүй. Тэрнээс судлагдаад бүх зохиол, туурвисан **номнууд** нь гарч ирээд ингэх юм бол Зая гэгээн, Ламын гэгээн эд нартай бас нэлээн дүйцэхүйц ойролцоо очихоор ийм хүн байсан гэж ярьдаг юм билээ.

Асуулт:-Бугатын хүрээний тухай ярьж өгөхгүй юу?

Хариулт:-Бугатын хүрээ бас өөрийн энэ бол Төвд хүн анх эхэлж байсан Төвд эхтэй. Манай хийд чинь анх эхэлж байгуулагдахад манай хийдийн тэргүүн хамба маань Бугатын хүрээний их үнзад хийж байсан Чойсүрэн гэж ийм гэлэн хүн байсан. Тэр хүн анх эхэлж тэргүүлж байсан. Тэр хийдийн дэгээр Төвд дэгтэй. Манай хийд чинь монголд бараг манай энэ дэгтэй нийлэх дэгтэй газар байдаггүй. Тэр үеийн Төвд хүн дэглэж байсан. Тэр хүрээний дэгээр хурал номын ажлаа явуулж байгаа.

Асуулт:-**Хадатын** хүрээний тухай

Хариулт:-**Хадатын** хүрээ олон сайн лам нартай тийм хүрээ байсан. Одоо энэ хүрээний лам нар зонхилох нь яасан хийдийг байгуулагдахад. Манай **Хадатын** хүрээний **Балсамбуу** үнзад гэж их сайхан дуутай, үнзадтай тийм хийд байсан гэж.

Асуулт:-Хэд орчим лам **хуврагатай** байсан юм бол?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Хариулт:-**Хадатын** хүрээ чинь 200 гаран ламтай, 6 дугантай байсан гэсэн байхаа, одоо хүрээнийх нь хуучин туурь юмнууд байдаг. Хөгшчүүл очоод энэ тийм тийм дуган байсан гээд ямар ч байсан 6 дугантай, 200 гаран ламтай.

Асуулт:-Чойр үздэг байсан уу?

Хариулт:-Чойр нэг их үздэггүй байсан юм шиг байна лээ.Энэ хавьд чинь ганц Чойр үздэг төв чинь Цоржийн хүрээ гэж **Хүрээ маралд** байгаа тэр хүрээ чинь **чойроор** монголдоо. Бүр өмнөөс хүмүүс ирж **чойр** үздэг байсан тийм хийд гэсэн.

Асуулт:-Шинэ хийдийн гол шүтээн нь ямар бурхан байдаг вэ?

Хариулт:-Манай хийдийн гол шүтээн бол анх эхлээд байгуулагдахад хөгшчүүл ярьж байгаад **Хадатын** хүрээ нь **лхам, Жамсран** хоёр гол шүтээнтэй байсан юм билээ, Бугатын хүрээ болохоор **Чойжин, Лхам** хоёр гол шүтээн байсан, Сангийн далай баруун хүрээ болохоороо **Гомбо** гол шүтээн байсан. Манай нутагт **Чойжин** сахиус гэж юм байдаг. Эд нар бас өөр газарт байдаггүй нэг тийм өвөрмөц онцлог юм байдаг юм билээ. Манай энд чинь айл болгонд буудаг сахиус гэж.

Асуулт:-Далай багшийн хажууд байдаг **Найчин чойжин** гээд байгаа шүү дээ, тэрэнтэй төстэй гэсэн үг үү?

Хариулт:-Одоо бол тэр л бий.

Асуулт:-Тэр болохоор биеэрээ буудаг?

Хариулт:-Тэгэхдээ биеэрээ буудгийг нь гүртэн гэдэг байсан шүү. Сахиус гэдэг нь болохоороо нохойд уруулаагүй, задгай судастай бас нэг тийм шинжүүд байдаг гэсэн. Тийм шинжтэй хүнд наана салах гэж нэг тийм юм. Тэр нь болохоор ташуур ч юмуу, пүрэв ч юмуу, очир ч юмуу нэг юманд ингээд хадаг яндар үячихсан, тэр нь **аравнайтай**, тэр нь **Лхамын** сахиус, **Чойжилийн** сахиус, **Гунайн** сахиус, **Гомбын** сахиус гээд олон янзын сахиус бий л дээ. Түрүүний тэр сахиул барьдаг хүн бариад наана нь тусгай хүн **солхо** гэж нэг номыг нь уншаад тэгээд ингэж чичирч бүүж, тэгээд амьтан хүн аврал айлдахад би ингэж өвдлөө **яхав ийхэв** гэж асуухад тийм тийм юмнаас болсон ингэсэн тэгсэн **байнаа** гэдэг тийм юу хэлдэг тийм нэг онцлог юм манай энд бас байдаг юм.

Асуулт:-Дээр үед Далайн хүрээнд бас тийм тусгай дацан байсан гэл үү?

Хариулт:-Чойжингийн дуган гэж байсан юм гэнэ лээ, **гүртэнгүүд** буудаг. Бууна гэдэг нь болохоороо биеэрээ чичирч ингэдэг. Тэгэхэд 360 бүүж чадах юм бол жинхэнэ гүртэн тодордог. Жилийн юу бол 360-даа хүрч чадахгүй бүүхаа больчихдог байсан юм гэнэ лээ. Дээр үед манай энд **Лот** гуай гэж нэг хүн байсан гэсэн. Тэр хүн болохоор дорой доожоо муутай хүүхэд байсан юм байна л даа. Тэгээд чичрээд буудаг. Тэгсэн чинь нөгөө үе тэнгийнхэн нь дооглоод. Тэр жинхэнэ 360 дахиа буулгахаар одоогоор 5 кг орчим гэж байгаа юм, тийм хүнд төмөр дүүлга толгойд нь өмсүүлээд бүчилж байгаад тэгээд буулгадаг байсан юм гэнэ лээ. Тэгээд тэр **Лот** гуайн бүүх ээлж нь болсон юм гэнэ лээ. Тэгсэн чинь **үеийнхэн** нь дооглоод **наадахыг** чинь малгайг нь тавиад, бүчийг нь **чангалчихаар** муужраад ойчно гэж байсан юм байна л даа. Тэгсэн чинь бүүгаад газар завилаад сууж байгаа хүн чинь хөөрөөд дуганы таазанд тулах гээд байсан гэсэн. Тэгж хүчтэй бүүж байсан. Тэгээд жинхэнэ гүртэн хүн

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

байсан байна гэж. Жинхэнэ гүртэн нь тэгж тодордог байсан юм гэнэ лээ. Сахиус буудаг **чойжингийн** дуган гэж дуган байсан юм гэнэ лээ,

Асуулт:-Далайн хүрээний Даш гүртэн гэж мундаг лам байсан гэсэн?

Хариулт:-Даш гүртэн гэдэг хүн чинь жинхэнэ юуны дацанд сууж буулгадаг, жинхэнэ өөрийнхөө биеэр буудаг хүн байсан юм гэнэ лээ. Тэргүүн лам. **Хадатын** хүрээн дээр ч гэсэн бас тийм буудаг хүн байсан гэж.

Асуулт:-Бууна гэдэг чинь?

Хариулт:-Хөгшчүүлийн ярьж байгаагаар бол нэг ёсондоо **бурханы** юу биед нь шууд очоод өөрийн мэдэлгүй шууд тэгж тийм тийм юм болсон байна гэж хэлдэг. Тэр энгийн хар хүн байсан юм гэнэ лээ **Хадатын** хүрээн дээр. Өөрийн мэдэлгүй болж буудаг тийм л хүн байдаг байсан гэж хөгшчүүл ярьдаг юм. **Хадатын** хүрээн дээр тийм буудаг хүн байсан юм гэнэ лээ, нэрийг нь сайн санахгүй байна. Тэгсэн чинь тэр буу **цэнэглэчихээд** намайг **буудаадах** гээд хүн хүний урдаас хэлээд. Зундуйдорж гуай гэж нэг их зүрхтэй, зоригтой юмнаас айдаггүй лам байсан гэнэ лээ. Тэр лам тойроод гараад ирсэн чинь лам нар ингээд хуйлраад **зугатаагаад** байсан гэнэ лээ. Та нар чинь юу болоод яагаад байна гэсэн чинь энэ Гүүш гуай намайг **буудаадах** гээд цэнэглэчихсэн буу өгөөд байна гэсэн гэнэ лээ. Зундуйдорж гуай дээр чинь шууд **буугий** нь аваад үнэн гүртэн бол босоод ирнэ, худлаа гүртэн болон үхээд өгнө биз гээд буудаж **унагаачихаад** дээрээс нь **буугий** нь шидчихээд яваад өгсөн гэсэн. Навс гээд хэвтчихсэн гэсэн. Тэгээд цай чанах хугацаа болсон чинь чичрээд босоод ирсэн гэсэн. Энэ чинь үнэн гүртэн юм байна шүү гээд итгэж байсан гэсэн.

Асуулт:-37 оны хэлмэгдүүлэлтийн үед үү?

Хариулт:-Тийм. Баригдаад урд хогийн толгой эд нарын далангийн наад үзүүрийн **жалгад** буудуулж байсан юм гэнэ лээ. Тэгээд буудахад нь шууд эрхий хуруугаа нулимаад буудсан газар нь ингээд дарахад, сум орсон газар нь дарахад эдгээд байсан гэсэн. Тэгж **ид хаваа** үзүүлж байсан юм гэнэ лээ. Тэгээд хөөсөөр тургиад хөөрөөд байсан юм гэнэ лээ.

Тэгэхэд Наран гэгээний дараагийнх нь дүр 16 настай хүүхэд бас аавтайгаа цуг хэлмэгдэж байсан. Тэр **болохоор** Даш **гүртэнгийн** хүүхэд нь байсан юм байна лээ. Тэгээд тэр хүүхэд нь аав та ингэж зовж байхаар бушуухан яв, оч гээд байсан, тэгээд өөрөө шууд буудуулаад за за больё гээд тэгээд ид хаваа үзүүлсэн гэсэн. Тэгээд шууд нэг буудахад нь **өнхөрөөд** өгсөн, тэгээд үхсэн юм гэнэ лээ. Тэгээд тэр шөнөдөө шарил нь алга болчихсон юм гэнэ лээ. Тухайн үед нутгийн ард түмэн хүндэтгээд нэг газар аваачаад оршуулсан уу, яасан. Тэгэхийн завдал болоогүй шөнөдөө алга болчихсон, бараг дээшээ хөөрөөд явчихсан байх л гэж тухайн үедээ тэгж яригдаж байсан гэж ярьдаг юм.

Асуулт:-Далайн хүрээний Наран гэгээний хойд дүр тодрох болов уу?

Хариулт:-Тодроод байх юм, манай энэ гэгээний дүр тодрох байлгүй дээ гэж боддог юм шүү дээ. Одоохондоо яг тодруулах юу ч алга байна, газар газар тодорч л байгаа, тийм учраас тодрох байхаа.